



МОНГОЛ УЛСЫН  
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН  
ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА

2022 оны 09 дугаар сарын 19

№ 04/20

Улаанбаатар хот

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА, БРИГАДЫН ГЕНЕРАЛ  
ТАНАА

Иргэн [redacted] "2022 оны 04 дүгээр сарын 07, 08-ны өдөр болсон цуглаанд оролцсон эсэхийг тодруулж, мэдээлэл өгөхдөө миний гар утасны дугаарыг аав Д.Мягмараас авсан нь хувийн мэдээллийг хууль бусаар цуглуулсан, хувийн нууцаа хамгаалуулах эрхийг зөрчсөн. Түүнчлэн мэдээллийг олон нийтэд албаны байр сууриа илэрхийлэх зэрэг хувь хүнийг тодорхойлохгүй бусад арга хэлбэрээр өгөх боломжтой байхад утсаар холбогдсон нь үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөнд халдсан гэж үзэх үндэслэлтэй" гэх агуулгатай гомдлыг Комисст 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдөр гаргажээ.

**Нэг. Үйл баримт**

Гомдол шалгах ажиллагааны хүрээнд Төрийн тусгай хамгаалалтын газрын холбогдох албан тушаалтнаас удаа дараа тайлбар авч, иргэн М.Энхбадралын 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдөр бичгээр гаргасан нэмэлт тайлбарт тусгагдсан асуудлыг нягтлахад дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

1. Иргэн [redacted] утасны дугаарыг нээлттэй эх сурвалжаас буюу 2022 оны 04 дүгээр сарын 07, 08-ны өдрүүдэд Улаанбаатар хотын тодорхой байршлуудад зохион байгуулагдсан жагсаал, цуглаанд оролцогчдоос Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсэн шаардах бичгээс авсан гэх Төрийн тусгай хамгаалалтын газрын Захиргааны удирдлагын газрын дарга [redacted] Комисст өгсөн тайлбар нь баримтаар нотлогдохгүй байна.

2. Төрийн тусгай хамгаалалтын газраас иргэн [redacted] 9910XXX1 дугаартай утсаар холбогдож, "Сүхбаатарын хөшөөний тугны сууриас хойш байрлах талбай төрийн тусгай хамгаалалтад байх тул талбайн уг хэсэгт цуглаан зохион байгуулахыг хориглодог" болохыг сануулсан байна.

**Хоёр. Гомдолд холбогдох хүний эрхийн эрх зүйн зохицуулалт**

1. Халдашгүй чөлөөтэй байх, хувийн нууцаа хамгаалуулах эрх

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад "Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь

150060053

D:\2022 on\A4. month9.docx

хязгаарлахыг хориглоно ... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалттай төсөөтэй хүний эрх, эрх чөлөөг тус улсад 1976 оны 03 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭТОУП)-ын 9, 17 дугаар зүйлд баталгаажуулсан байна. Пактын 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй” гээд хүнийг хууль бусаар баривчлах, цагдан хорихын эсрэг баталгааг бүрдүүлэх хэм хэмжээг Пактын тус зүйлээр тогтоожээ. Түүнчлэн, Пактын 17 дугаар зүйлд хувийн нууцаа хамгаалуулах эрхийг дараах байдлаар баталгаажуулжээ. Үүнд:

1. Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно.
2. Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй.

Монгол Улсын Үндсэн хууль, ИБУТЭТОУП-ын дээрх заалтуудын энгийн утга санаанаас харахад Монгол Улсын Үндсэн хуулиар иргэний халдашгүй чөлөөтэй байх эрхийг баталгаажуулсан байдал нь олон улсын гэрээний заалтаас өргөн хүрээтэй байна. Тодруулбал, ИБУТЭТОУП-ын 9 дүгээр зүйлийн агуулга хүнийг хууль бусаар баривчлах, цагдан хорихоос хамгаалах агуулгатай бол Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт нь дээрх тохиолдлоос гадна мөрдөн мөшгих, бусад байдлаар хүний эрх чөлөөг хязгаарлах, хувийн нууц, гэр бүл, орон байрыг хамгаалах агуулгыг илтгэж байна. Хүний хувийн байдал, нэр төр, нууц, гэр бүлийн халдашгүй байдлыг ИБУТЭТОУП-ын 17 дугаар зүйлд тусад нь баталгаажуулжээ.

2022 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болсон Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль нь Монгол улсын нутаг дэвсгэрт хүний хувийн мэдээллийн халдашгүй байдал, халдашгүй чөлөөтэй байх эрхийг хамгаалах зорилготой бөгөөд хуулийн үйлчлэлд хамаарах харилцаанд “хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх”, “хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх”, “ялгаварлан гадуурхахгүй байх” зарчмуудыг тогтоосон байна. Уг хуулийн 6 дугаар зүйлд төрийн байгууллагаас хүний хувийн мэдээлэл цуглуулах зургаан төрлийн үндэслэлийг тогтоосны дотор мэдээллийн эзэн зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд зөвхөн хуульд заасан үндэслэлээр хувийн мэдээллийг цуглуулах, ашиглахаар заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтаар тогтоосон халдашгүй, чөлөөтэй байх эрхийн агуулгад “мөрдөн мөшгихөөс ангид байх” иргэний үндсэн эрхийг баталгаажуулсан байна. Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.12 дугаар хэсэгт “хууль бусаар мөрдөж мөшгих” гэмт хэргийг тогтоож, мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгисэн үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор заасан байна.

## 2. Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт “... Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван

жагсаал цуглаан хийх, эрх чөлөөтэй” гэж иргэний үндсэн эрхийг, ИБУТЭТОУП-ын 21 дүгээр зүйлд “Тайван хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт хийж болохгүй” гэж хүний эрхийг баталгаажуулсан байна. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлд “Хууль тогтоомжийн дагуу жагсаал, цуглаан зохион байгуулсан буюу түүнд оролцсоны төлөө хэнийг ч мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, аливаа хэлбэрээр гадуурхахыг хориглоно” гэж заасан.

#### **Гурав. Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн эсэх талаарх дүгнэлт**

1. Халдашгүй чөлөөтэй байх, хувийн нууцаа хамгаалуулах эрх зөрчигдсөн эсэх талаар

Иргэний утасны дугаар нь Хувийн мэдээлэл хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад заасан захидал, харилцааны мэдээлэл болох бөгөөд эзэмшигчийн хэн болохыг зарим төрийн, хувийн хэвшлийн байгууллагууд гар утасны дугаараар тодорхойлох боломжтой тул уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтад заасан хамгаалагдвал зохих хувийн мэдээлэл мөн. Төрийн тусгай хамгаалалтын газрын ажилтан 2022 оны 04 дүгээр сарын 07, 08-ны өдөр болсон жагсаал, цуглаанд оролцсонтой нь холбогдуулан иргэн [redacted] хувийн мэдээллийг олж авах идэвхтэй үйлдэл хийсэн байх бөгөөд хувийн мэдээллийг эзний шууд бус зөвшөөрлөөр буюу Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсэн шаардах бичгээс авсан гэх тайлбар нь нотлогдохгүй байна.

Хувийн мэдээлэл хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4, 3.5 дахь хэсэгт Гүйцэтгэх ажлын тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд тусгайлан зааснаас бусад харилцааг тус хуулиар зохицуулахаар, уг хуулийн 6 дугаар зүйлд мэдээллийн эзэн зөвшөөрөөгүй бол төрийн байгууллагаас гагцхүү хуульд заасан үндэслэлээр хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах зарчмыг тогтоосон. Төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаа нь Гүйцэтгэх ажлын тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зохицуулагдахгүй бөгөөд Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагаас хуулиар төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоосон Улсын Их Хурлын чуулган, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ, хурал, зөвлөгөөн явагдах танхимд болон хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийх техникийн үзлэг, шалгалт гүйцэтгэх ажилд хамаарахгүй” гэжээ.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 3 дугаар зүйлд “...Төрийн тусгай хамгаалалт нь аюулгүй байдлыг нь хангах зорилгоор хуулиар төрийн тусгай хамгаалалтад авахаар тогтоосон төрийн байгууллага, тэдгээрийн зарим үйл ажиллагаа, албан тушаалтан, иргэний амь бие, ордон, өргөө, зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийг хамгаалахад чиглэсэн мэргэжлийн болон бусад байгууллага, албан тушаалтны харилцан уялдаатай цогцолбор үйл ажиллагаа” гэж тодорхойлж, мөн хуулийн 4 дүгээр зүйлд энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхэд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, нууцыг чанд хадгалах, иж бүрэн байх зарчмуудыг мөрдөхөөр заасан. Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2.4 дэх заалтад Монгол Улсын Төрийн ордонг төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоож, хуулийн 11 дүгээр зүйлд төрийн тусгай хамгаалалтын газрын, 12 дугаар зүйлд төрийн тусгай хамгаалалтын

газрын даргын, 15 дугаар зүйлд төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн эрх, үүргийг тус тус заасан байна. Тухайлбал, Төрийн тусгай хамгаалалтын газар, алба хаагч нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх үүднээс төрийн тусгай хамгаалалтын бүс, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд нэвтрэн орох журам, дэглэм тогтоох, хяналт тавих, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор төр, захиргаа, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас хамгаалалтын ажлын нөхцөл байдалтай холбогдох мэдээ, судалгаа гаргуулж авах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заажээ. Харин энэ зорилгоор хувь хүний мэдээллийг цуглуулах, ашиглах бүрэн эрх танай байгууллагад олгогдоогүй байна.

Гагцхүү хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөнд халдах нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээгээр тогтоосон үндсэн зарчим юм. Холбогдох хууль тогтоомжоор олгоогүй бүрэн эрхийг хэрэгжүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын газрын алба хаагчийн үйлдэл нь хүний эрхийг зөрчсөн байна.

## 2. Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө зөрчигдсөн эсэх талаар

Иргэн М.Энхбадрал гомдолдоо “төрийн тусгай хамгаалалтын газар 2022 оны 04 дүгээр сарын 07, 08-ны өдрүүдэд болсон жагсаал, цуглаанд оролцсон гэх иргэдтэй утсаар холбогдож, сануулга, мэдэгдэл өгсөн нь тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөнд халдсан гэж үзэх үндэслэлтэй” гэж дурджээ.

Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэгт заасны дагуу Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайн Төрийн ордны нутаг дэвсгэрт хамаарах хэсэгт Монгол Улсын иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор жагсаал, цуглаан хийхийг хоригложээ. Улсын Их Хурлын 2001 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 16 дугаар тогтоолоор Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээг төрийн ордноос зүүн, баруун зүгт тус бүр 33 метр, урд, хойд зүгт тус бүр 80 метр хүртэл байхаар тогтоосон нь гомдолд холбогдох үйл явдал болох үед мөрдөгдөж байв. Уг тогтоол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 37 дугаар тогтоол гарснаар хүчингүй болж, төрийн ордны нутаг дэвсгэрийг төрийн ордны баруун, зүүн талын хашаа болон төрийн ордны хойд талын цэцэрлэгт хүрээлэнгийн урд талын хашаа, төрийн ёслол хүндэтгэлийн өргөө цогцолборын барилгын бүтээцийн урд хязгаараар шинэчлэн тогтоосон болохыг дурдах нь зүйтэй.

Төрийн ордоныг хамгаалах зорилгоор Сүхбаатарын талбайн Төрийн ордны нутаг дэвсгэрт хамаарах хэсэгт нь аль болох, тухайн хэсэгт нэвтрэхэд мөрдөгдөх дэглэмийн талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх нь Төрийн тусгай хамгаалалтын газрын чиг үүрэгт хамаарч болох боловч ийм арга хэмжээг хүний хувийн мэдээллийг цуглуулж, хувь хүнд чиглэсэн байдлаар хэрэгжүүлсэн нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөгөө хэрэгжүүлэх хувь хүний эрмэлзлэл, зоригийг мохоох үр дагавар үүсгэж болзошгүй, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлд нийцэхгүй юм. Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний баталгаа нь жагсаал, цуглаан үргэлжлэх явцад төдийгүй, үйл явцын өмнөх бэлтгэх үе шат болон дуусгавар болсоны дараах үйл явцад ч хамааралтай болохыг Монгол Улсын олон улсын гэрээгээр тогтоосон болно. Төрийн ордны нутаг дэвсгэрт жагсаал, цуглаан хийх нь хориотой болох тухай мэдээллийг жагсаал, цуглаанд оролцогчид

тусгайлан чиглэсэн байдлаар биш, олон нийтэд ерөнхийд нь чиглэсэн хэлбэрээр зохион байгуулах боломжтой байсан гэх гомдол гаргагчийн тайлбар үндэслэлтэй байна.

### Дөрөв. Комиссын гишүүний шаардлага

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь хэсэгт тус тус заасан Комиссын гишүүний бүрэн эрхийн хүрээнд хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, дахин зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээ авахыг шаардаж байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг зөрчиж, иргэн \_\_\_\_\_ гар утасны дугаарыг зөвшөөрөлгүй олж авч, жагсаал цуглаанд оролцсон үйлдэлтэй нь холбогдуулан харилцсан албан тушаалтан, алба хаагчид хуулиар тогтоосон журмын дагуу хариуцлага тооцох;

2. Хүний хувийн мэдээлэл хамгаалах, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөө, хуулиар хүлээсэн чиг үүргээ хүний эдгээр эрх, эрх чөлөөг хангасан байдлаар хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны арга хэмжээнд нийт алба хаагчдаа хамруулах;

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт "Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй" гэж заасан.

Шаардлагыг хэрэгжүүлсэн талаарх мэдээллээ холбогдох баримтын хамт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор ирүүлнэ үү.

ГИШҮҮН



Г.НАРАНТУЯА